

Зуны амралт буюу Явдаг дэлгүүр

Т.Талсан



Т. ГАЛСАН

«ЗУНЫ АМРАЛТ БУЮУ ЯВДАГ ДЭЛГҮҮР» ХЭМЭЭХ ҮЛГЭР (Сургуулийн дунд насныханд)

“БНМАУ. Ардын боловсролын яамны Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар” Улаанбаатар хотноо 1986 онд эрхлэн хэвлүүлсэн
“ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД”
НОМООС

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн газарт 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

-

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.

Б
БОЛОР ДУРАН 2.0
АЛДАА ШАЛГУУР

**“БОЛОР ДУРАН”
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР

«ЗУНЫ АМРАЛТ БУЮУ ЯВДАГ ДЭЛГҮҮР» ХЭМЭЭХ ҮЛГЭР

«АЗИ ТИВИЙН
Швейцар» гэж
Алдар суу нь
Дэлхийд мандсан.

Мөрөн голын нь
Цэнгэг усанд
Мөргө, тул
Сэлүүрдэн уралдсан

Гурвалжин уулсын нь
Энгэр ээвэрт
Гур, зүр нь
Эрхлэн наадсан

Цастай тайгынх нь
Ой царамд
Цаа буга
Ойлон цойлсон

Хөвсгөл аймгийн
Нутагт гэнэ ээ
Хөхөөн дуутай
Зун цагт гэнэ ээ.

Захидлаар танилцсан
Хөдөө найзындаа
Зандан гэдэг пионер
Хотоос ирж гэнэ ээ.

Алс гарагийн
Сайн санаат зочин
Айлчилсан юм шиг
Самбуу гуайнх баясжээ.

Самбуу гэдэг

Өндөр л болохоос
Сахал сүрхий
Өтгөн болохоос

Яг л өөрийнх нь
Аав шиг санагдлаа.
«Яваад л ирэв үү
Аль вэ, үнсье» гэлээ.

Дулам гуай гэдэг
Намхнаас биш
Дуу нь баахан
Чангаас биш

Яг л өөрийн
Ээж шиг харагдлаа.
«Янзага юм даа!» гээд
Энхрийлэн үнслээ.

Урьд нь зөвхөн
Захидлаар харилцаж
Улирал бүхэнд
Сурлагаар уралдаж

Өөдсөн чинээ
Зургаа солилцсон найз нь
Өөртэй нь харин
Чацуу байв гэнэ.

Унааны хурдаар
Давхих нь харин
«Улаан дарцгийн»
Дайчин шиг харагдав гэнэ.

«АМАР, АМАР!
ОВООХОН АМАР!
АЛСААС ИРСНИЙХ
ОЛИГТОЙХОН АМАР!

ГЭРИЙН СҮҮДЭР
ДАГААД Л УНТ!
ХИВС ДЭВСЭЖ
ТАРВАЛЗААД Л ХЭВТ!

АЙРАГ ТАРГААР
АХИУХАН УГЖУУЛ!
ААРУУЛ ӨРӨМ
ИДЭЭД Л ХАЖУУЛ!» гэж

Өтгөн сахалтай
Самбуу гуай зөвлөнө.
Өрөм ааруулаар
Дулам гуай дайлна.

Алсын замд
Агсагадаад ч гэх үү
Агаар солиод
Алжаагаа ч юм уу

Их гэрийн гадаа
Зандан унтсаар л....
Ишиг, хурга
Залхуу хүүгээс үргэсээр л...

«Босдоггүй унтаахай!» гэж
Богширго жиргэнэ.
«Хөөрхөн хүүхэлдэй» гэж
Хөхөө донгодно.

Сэрээч! сэрээч! гэж
Царцаа шаргина.
Сээр хүзүүг нь
Шумуул хазна.

Уралдъя, уралдъя! гэж
Унага янцгаана.
Эрхэлье, эрхэлье! гэж
Эрвээхэй урина

Замд ядарсан
Зандан хүү
Залхууд ялагдсан
Ганган дүү

Уугаад л...
Идээд л..
Унтаад л...
Эвшээгээд л...

Гурав хоног
Гулдайжээ.
Тав хоног
Тарайжээ...

Самбуу гуайн хэлдгээр
«Сайхан» амарчээ.
Дулам гуайн зөвлөснөөр
Тухтай «жаргажээ».

Хүүжий найз нь
Гэтэл
Хөхөөн дуунаар
Сэрээд л...

Цэцгэн дундуур
Жирийгээд л...
Цэнгэг голд
Сэлээд л...

Хонь хургаа
Түжийтэл хяргаад л...
Холын бэлчээрт
Түнтийтэл таргалуулаад л...

Баяр жаргалтай
Дуулж явдаг гэнэ ээ
Бадармал жавхлантай

Дүүлж явдаг гэнэ ээ.

Халуун өдрийн
Мансуурам үдэд
Хаяанд унтсан
Манай Зандан

Хамаг бие нь
Улхайв гэнэ.
Хар даран
Уйлагнав гэнэ.

...Улаанбаатараас
Уригдсан Зандан
Хөдөө ирсэн
Хүндэт зочин

Гахайн торой
Болчихсон байна гэнэ.
Хашаанд хэвтээд
Бордуулж байна гэнэ.

Урьд өмнө нь
Торой үзээгүй
Унага, тугал
Тоос татуулан үргэж

Цовоо ишиг
Нуруун дээгүүр нь
Цовхрон дэвхрэн
Наадаж байна гэнэ.

Торой-Занданг
Аав нь хараад.
Толгой сэгсрэн
Асгалуулах нь тодхон.

Ээж нь яг л
Цэцэрлэгийн охин шиг

Эхэр татан
Цийлэлзүүлэх нь содон.

Хүүжий ирж
Занданг сэрээлээ.
Хөл гард нь
Засал-иллэг хийлээ.

Цэцгэн дундуур
Хөтлөн гүйв.
Цэнгэг усаар
Шавшин наадав.

«БИ ПИОНЕР
ЧИ ПИОНЕР
БИД ХОЁР
МОНГОЛЫН ПИОНЕР!

АМАРНА ГЭДЭГ
УУЖ ИДЭХИЙН НЭР БИШ
АЙЛЫН ХАЯА
УНТАЖ ХЭВТЭХ ОР БИШ!

НЭРТЭЙГЭЭР НЬ ЧИ
НЭХИЙД ӨЛГИЙДҮҮЛЧИХ
МЭЭМЭЭ ХӨХЬЕ ГЭЭД
НЭХЭЭД УЙЛЧИХ! гэж

Шударга Хүүжий
Занданг зэмлэв гэнэ.
Шулуухан ил үгээр
Зад шүүмжлэв гэнэ.

Хотын хүү
Айхавтар ичив.
Хоёр хацар, нь
Алим шиг улайв.

Цамцаа дэрвүүлэн

Огцом дэгдэв.
Самбуу гуай дээр
Очиж харагдав.

«Ай балар
Хоржоонт үг минь хатуудлаа
Анд найз минь
Хот буцахаар шийдлээ!» гэж

Хүүжий бодлоо.
Биеэ зэмлэлээ.
Хөлийн хурдаар
Гэр уруугаа гүйлээ.

— УУЧЛААРАЙ
САМБУУ ГУАЙ!
УНТАА ДҮҮГЭЭ
САЙТАР ЗЭМЛЭЭРЭЙ!

УУГААД Л...
ИДЭЭД Л...
УНТААД Л...
ЭВШЭЭГЭЭД Л...

ХЭВТСЭЭР БАЙТАЛ
ГЭДЭС СУНАЧИХ НЬ ЭЭ
БӨВ БӨӨРӨНХИЙ
БӨМБӨӨЛЭЙ БОЛЧИХ НЬ ЭЭ

АЯГҮЙ БОЛ
ТОРОЙ БОЛОХ НЬ ЭЭ
ААВ, ЭЭЖ МИНЬ
ТАНИХГҮЙ БОЛОХ НЬ ЭЭ

БИ ТАНАЙ
ХҮҮЖИЙ ШИГ Л АМАРЪЯ
БЭРХ АЖИЛД
ХҮЧИН СЭЛБЭЕ! гэж

Улаан бүчээ
Зүүгээгүй ч гэсэн
Ухаалаг хүү
Пионерын дүрмээр, ёсоллоо.

Урьд гарсан чихнээс
Хойно ургасан эвэр
Урт болдог гэж
Самбуу гуай магтлаа.

Найздаа шүүмжлүүлсэн
Өдрөөс хойш
Манай Зандан
Өөр болжээ.

Хотын гэмээргүй
Хоньчин болжээ.
Цэцгэн дунд
Цэнгэх болжээ.

Хоёр жилийн
Сувай юм шиг
Хонь болгоны
Сүвээ зузаараад л...

Өмнөд туйлын
Цасны баавгай шиг
Өнгө зүс нь
Цав цайгаад л...

Иргэн хонь нь
Сүүлээ даахгүй
Энд тэнд
Сүүжилдэж хэвтээд л...

Ишиг хурга нь
Сүүгээ хөхөх дургүй
Эхээсээ зайдуу
Сүрэглэн мөргөлдөөд л...

Хонгор зул
Цэнхэртсэн хөндийд
Хонин сүрэг
Сувдран байна.

Хотын, хөдөөгийн
Хоёр пионер
Хорвоогийн сонин
Хүүрнэн сууна.

— УУЛ УС НЬ
ӨНГӨТ КИНО
УРСГАЛ ГОЛ НЬ
МӨНГӨН ДОЛГИО

АН АМЬТАН НЬ
ЗОО ПАРК
АЙРАГ ТАРАГ НЬ
ЖҮРЖИЙН ОХЬ

ЭЭ ДЭЭ ЭНД Ч
САЙХАН ЮМАА! гэж
Их хотын хүү
Санаа алдав.

ААВ ЭЭЖ НЬ
ХӨДӨЛМӨРИЙН БААТАР
АЖИЛ ҮЙЛС НЬ
ТҮҮХ ШАСТИР

НАВЧ ЦЭЦЭГ НЬ
АЙЛЫН ХОЙМРЫН ХИВС
НАР ХУР НЬ
АЛТ МӨНГӨН УТАС

ХӨДӨӨ Ч НЭЭРЭЭ
БАХАДМААР САЙХАН ШҮҮҮ ! гэж
Хүүжий хүү

Баясан өгүүлэв.

Яг энэ үеэр
Янзын юм болов.
Баруун хойноос гэнэт
Бялуу үнэртэв.

Бас шинэхэн алим
Бал бурам
Баавгайт чихэр
Бялуурмаар үнэртэв.

ХҮН ҮНЭМШМЭЭРГҮЙ! ... гэж
Зандан гайхав.
Хүнсний дэлгүүрийн
Үнэр юм даа! гэв.

ЗАРИМ ГАЗАР
ЗАГАС, ЖАРААХАЙГААР
ӨӨР ТИВД
ҮЗЭМ ЖИМСЭЭР

АФРИКИЙН ЭРЭГТ
АЛИМ ГАДИЛААР
АВСТРАЛИЙН ХОТОД
АМЬД ТУУЛАЙГААР

ХУР ОРОХЫГ
ҮЗСЭН ГЭДЭГ.
ХУУДУУГҮЙ ЭНЭ
ҮНЭН ЮМ ГЭДЭГ.

Огторгуйгаас алим
Ойчих юм байлгүй!
Агаараас бурам
Асгарах юм байлгүй... гээд

Тэнгэр өөд Хүүжий
Алгаа тослоо.

ТЭНЭГЛЭХЭЭ БОЛЬ! гэж
Айлчин найз нь зэмлэлээ.

ҮҮЛНИЙ ЦААНААС
ИХ ДЭЛГҮҮР
ҮЕ ҮЕХЭН
ЭНД БУУДАГ ЮМ.

ХУДЛАА ГЭВЭЛ
ААВААС АСУУ!
ХУРГАНААС БУСАД
ХОНИНООС АСУУ

НОДНИН МАНАЙХ
ХОРДИЛ САРЬДАГТ ЗУССАН ЮМ
НОГОО ХӨӨЖ
ХОЛЫН ОТОРТ ГАРСАН ЮМ.

САЙХАН ХАНГАЙ ГЭЖ
ШААЗГАЙ ШАГШААД Л...
«ХҮНИЙ ЭНХЖИН!» гэж
ХӨХӨӨ ХӨВШӨӨД Л...

«УС НЬ ЦӨЦГИЙ» гэж
ГАЛУУ ГАНГАНААД Л...
УРГАМАЛ НЬ ЗӨӨХИЙ!» гэж
ХАРААЦАЙ ЖИРГЭЭД Л...

Хурганы ноос
Хуруу хуруу ургаад л...
Ахрын урт
Атга атга дүүрээд л

Төлөгний сүүл
Төмпөн шиг овойгоод л...
Хонины ууц
Ховоо шиг халбайгаад л...

Сүү цагаа

Саваа халих үеэр
Сүргийн маань бэлчээрт
Их дэлгүүр ирсэн юм.

Амтат бялуу
Үзэмтэй еэвэн үнэртүүлсээр
Алим жимс
Үрлэн чихэр бөндгөнүүлсээр

Таван зуун янзын
Жижиг сажиг бараатай
Тавин янзын
Жимс чихэртэй

Баян дэлгүүр
Тэнгэрээс буусан юм.
Бал нь чинэсэн
Цэцгэн дунд буусан юм.

Алаг солонгон дээгүүр
Гулсан буух
Арван давхар
Дэлгүүрийн бараанаар

Зариа унаад
Цаатнууд ирсэн юм.
Загасаа мартаад
Анчид ирсэн юм.

Оторт яваа
Эрэлхэг малчдыг
Олж ирдэг
Их дэлгүүр ачтай

Ардаг тарган
Сүргийн бэлчээрт идсэн
Алим жимс
Шүлс асгамаар амттай! гэж

Адтай Хүүжий
Гараа өргөх үед
— Арай ч дээ... гэж Зандан
Гайхан маргах мөчид

Алим жимс
Үрлэн чихэр бөндгөнүүлсээр
Амгат бялуу
Үзэмтэй чихэр үнэртүүлсээр

Эд бараа
Боодол боодлоор, нь өрсөн
Идэш ууш
Лангуу дүүрэн өрсөн

Арван цаанд
Хөллөсөн дэлгүүр
Ажилсаг жаалуудын
Хажууханд ирлээ.

«СҮҮНИЙ ЗАЙРМАГААС
БУСАД НЬ БИЙ!
ШӨНӨГҮЙ БОЛГОХ
ДЭНЛҮҮ Ч БИЙ!

ХАЛУУН ОРНЫ
ЖИМС Ч БИЙ
ХАН АЛТАЙН
АРЦ Ч БИЙ!

ӨӨРИЙНХӨӨ ДУРТАЙГ
АВААРАЙ АВААРАЙ!
ҮС, НООСОО
АВЧ ИРЭЭРЭЙ, АВЧ ИРЭЭРЭЙ!

Алиа худалдагч
Цээлхэн хоолойгоор дуулав
Ачаа бараагаа
Цэцгэн дээгүүр дэлгэв.

Том түрийвчээ
Өвөртөө хийгээд
Тохсон богцоо
Өд шиг дэрвүүлээд

Яаран сандран
Самбуу гуай айсуй!
Явдаг дэлгүүрийн зүг
Оторчид ч айсуй!

Хоньчин гэдэг
Эгэл алдартай
Хотын даргаас
Их цалинтай

Тэр хүмүүс
Наргианч юм.
Дэг горим
Нарийнтай юм.

Дэлхийд хэн
Түрүүлж төрсөн нь
Дэлгүүрийн бараанаас
Түрүүлж авах юм.

«ХОЛЫН УУЛАНД
ӨӨРӨӨ ХҮРЭЭД ИРДЭГ
ХОВОР БАРАА
ӨРГӨЖ ТЭЭГЭЭД АВЧИРДАГ

АЧТАЙ ДЭЛГҮҮРИЙН
ХҮНД, ХЯМД БАРААГ
АХ НЬ ЖААХАН
ХӨНГӨЛЖ ӨГЬЕ!» гээд

Бага ангийн хүүхдийн
Бүх ном
Багтмаар түрийвчээ

Самбуу гуай нээлээ.

Боов гөөхий
Хайрцгаар нь авлаа.
Боорцог ёотон
Дээрээс нь нэмлээ.

«ТУСГАЙ ШАГНАЛЫН
НӨӨЦ» гэж
Тулам дүүрэн
Алим авлаа.

«АЛИМ АВААД
НАМАЙГ АВСАНГҮЙ!» гэж
Амт сайхантай
Жимс уйлагнав.

«ХОЛ ОЙРЫН ЗОЧДОД
ТАВАГЛАЯ ДАА!» гээд
Хоёр уут
Жимс нэмэв.

«ЖИМС АВААД
БИДНИЙГ ТООСОНГҮЙ» гэж
Чихэр бурам
Битүүхэн уйлагнав.

Амтганаас нь
Арван жинг
Шимтгэнээс нь
Шилэн хүүдийг

Торго дурдангаас нь
Долоон толгойг
Найргийн түүврээс нь
Найман шинийг

Хүнд ихтэй
Самбуу гуай авав гэнэ.

Хүүжий, Зандан хоёр
Сарлагийн шард ачаалав гэнэ.

Шивгэнэдэг радио,
Гар чийдэн нь
Шив шинэхэн
Зайтай боллоо гэнэ.

Эзэн нь тэжээл хийнгүүт
Хайртай радио нь
«ИХ БАЯРЛАЛАА!» гэж
Хашхирав гэнэ.

Хот газрын
Амтат чихрээр Самбуу гуай
Хоёр хүүгээ
Ав адилхан шагнав гэнэ.

Хонгор зул
Цэнхэртсэн хөндийд
Хорж хэвтсэн
Сүргийн дэргэд

Чихэр хүлхэнгээ
Бодлогоширсон Зандан
«ЧИ ЯМАР ХҮН
БОЛОХ ВЭ!» гэж асуулаа.

«ХОНЬЧИН ГЭДЭГ
АТААРХАМ АЖИЛ!
ХОРВОО ДЭЛХИЙД
АНХНЫ Л МЭРГЭЖИЛ!

ӨВӨГ ДЭЭДСИЙН МИНЬ
УЙДААГҮЙ АЖИЛ!
ҮЕИЙН ҮЕД
УСТАХГҮЙ МЭРГЭЖИЛ!

УДМАА ДАГАЖ БИ

ХОНЬЧИН БОЛНО
УС НУТАГТАА
ЭЗЭН СУУНА» гэж

Чихрээ нүцгэлэнгээ
Хүүжий хэллээ.
— ЧИ ӨӨРӨӨ? гэж
Найзаасаа асуулаа.

ХЭРВЭЭ ЧИ
ЭМЭГТЭЙ БАЙСАН БОЛ
ГЭР БҮЛ БОЛЖ
ЭНД ЧАМТАЙ АМЬДАРМААР БАЙНА.

Хотод өсөж
Торнисон болохоор
Хоньчин болж
Арай чадмааргүй байна.

ГЭХДЭЭ Л БИ
ХЭРЭГТЭЙ ХҮН БОЛНО
САЯНЫ АХ ШИГ
САЙН ХУДАЛДАГЧ БОЛНО

МАШИН ТЭРГЭЭ
ӨӨРӨӨ БАРЬДАГ
НАЙМАА ХУДАЛДААГАА
ҮНЭРХЭЛГҮЙ ХИЙДЭГ

АЛСЫН ОТОРЧИД ДЭЭР
ӨДӨР БҮР ОЧДОГ
АЛИМ ЖИМС
ӨВӨЛ ЗУНГҮЙ зөөдөг

БУЛГАНЫ АРЬС
БУГЫН ЭВРИЙГ НЬ
БУШУУХАН АВААЧИЖ
УЛСДАА ТУШААДАГ

ХОТОЛДОО ТУСТАЙ
ХҮН БОЛНО ОО!» гэж
Хотоос ирсэн
Хүү хэлэв гэнэ.

Түрүүнээс хойш
Ичингүйрсэн Хүүжий
Түс хийтэл
Инээд алдав гэнэ.

* * *

Дундуур бүгдийг
Дүүргэж өгдөг
Дутуу бүгдийг
Авчирч тусалдаг


Ачтай дэлгүүрийн араас
Даллав гэнэ.
«АХИН ИРЭЭРЭЙ!» гэж
Дуудав гэнэ.

Мөрөн голынх нь
Цэнгэг усанд
Мөргө, тул
Сэлэн уралдсан

Гурвалжин уулсынх нь
Эвэрт энгэрт
Гур зүр нь
Эрхлэн наадсан

Алсын харгуйд
ДЭЛГҮҮР далдрав гэнэ ээ.
Амар сайхандаа
Үлгэр ч жаргав гэнэ ээ.

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.



Өглөгийн эзний сонорт

×

Та манай номын санд хандив өргөж болно.

Таны хандивласан мөнгө:

- Хэвлэгдсэн номыг цахим хэлбэрт оруулах
- Цахимд оруулсан номыг ариутган шүүх
- Цахим технологийн тоног төхөөрөмж авах
- Цахим номын санг өргөжүүлэх
- Цахим номын сангийн чиглэлээр судалгаа хийж, сурч байгаа оюутан судлаачийг дэмжихэд зарцуулагдана.

Хандив өргөх данс "Хаан банк" 5027 8982 35 (төгрөг) ЦОГТ ОХИН ТЭНГЭР САН

Орау

1986 онд БНМАУ-ын Ардын боловсролын яамны Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар эрхлэн хэвлүүлсэн “ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД” номын Гарчиг :

“Цэнхэр эргүүлийнхэн буюу анхны гавьяа” хэмээх үлгэр

“Зөвлөлт хүн буюу улаан туг” хэмээх үлгэр

“Үгэн-эм” хэмээх үлгэр

“Хурдан байшин буюу олондоо тустай ойн автобус” хэмээх үлгэр

“Зуны амралт буюу явдаг дэлгүүр” хэмээх үлгэр

1986 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл :

Т. ГАЛСАН

ДЭГДЭЭХЭЙ НАСНЫ ҮЛГЭРҮҮД

(Сургуулийн дунд насныханд)

Редактор С. Надмид

БНМАУ

Ардын боловсролын яамны

Сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар

Улаанбаатар 1986 он

Хэвлэлийн редактор Ц. Сүхбаатар

Уран сайхны редактор П. Оюунцэцэг

Зураач Б. Төмөрбат

Техник редактор Р. Оюун

Хянагч Д. Цэнд-Аюуш, Д. Шүр

А № 96263

За № 186

ХГ № 40/86

Өрөлтөд 1986 оны 6 сарын 2-нд

Хэвлэлтэд 1986 оны 7 сарын 5-нд

Цаасны хэмжээ 84x108/32

Х. х. 3

ХНХ 5.04

Хэвлэсэн тоо 6000

Үнэ 2 тө.

Улаанбаатар 46

АБЯ-ны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцын газар Их сургуулийн
гудамж 3

Д. Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинатад хэвлэв.

Д. Сүхбаатарын талбай 2